

БАТЛАВ
“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Д.ОЮУНБОЛД

**“АВТО ЗАМЫН НОРМ НОРМАТИВЫН САНГИЙН ЦАХИМ СИСТЕМ”-ИЙН НЭМЭЛТ
ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2026 оны 02 сарын 25-ны өдөр

№ 2026/03

Улаанбаатар хот

1. Төсөл боловсруулах үндэслэл:
 - Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр 2025-2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөө
2. Төслийг хэрэгжүүлэхэд ашиглах, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд:
 - Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.2 дах заалт;
 - Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;
 - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
 - Кибер аюулгүй байдлын тухай хууль;
 - Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам;
3. Төслийн бүрдэл:
 - Авто замын норм нормативын сангийн цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын үе шатны тайлан;
 - Авто замын норм нормативын сангийн цахим системийн эх код бүхий хавсаргасан материал
4. Төсөл хэрэгжүүлэх үе шат:
 - 8 сар /Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш/
5. Төслийн хүрээнд гүйцэтгэх ажил:
 - Авто замын норм нормативын сангийн цахим системийн үндсэн мэдээллийг судлан одоогийн техникийн болон функциональ байдлыг бүрэн шалгаж, давуу тал болон сул талуудыг илрүүлэх танилцуулах, /аюулгүй байдал, ачаалал даах чадвар/
 - Өгөгдлийн сангийн бүтэц (товч загвар) боловсруулах;
 - Мэдээллийн санг бусад төрийн байгууллагын системтэй холбох /Зам тээврийн яам, Цахим харилцаа холбооны яам, Стандарт хэмжил зүйн газар/
 - Авто замын салбарын норм нормативын баримт бичгийг:

- Нэгдсэн ангилал, хугацааны болон бусад хэлбэрийн эрэмбэ дараалал, кодчилолтой болгох;
 - Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон хүчингүй болсон норм дүрэм стандартыг ил тод болгох;
 - Авто зам, замын байгууламжийн барилга угсралт, засвар арчлалт, зураг төслийн ажилд ашиглагдаж буй норм дүрэм, техникийн баримт бичиг, аргачлал, гарын авлагыг системд оруулж нэгдсэн цахим сан үүсгэх;
 - Баримт бичгийн төрлөөр ангилах;
 - Авто замын барилгын норм /ЗЗБНБД, БНБД/
 - Засвар арчлалтын норм, гарын авлага
 - Гүүр, хоолойн норм, аргачлал, гарын авлага
 - Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм дүрэм техникийн баримт бичгийг цахим системээр худалдан борлуулах, хавсралт файлыг татахгүйгээр нээж харах байдлаар оруулах;
 - Төрийн сангийн холбогдох дансийг системтэй холбох;
 - Хувь хүн, аж ахуй нэгж байгууллага шинээр бүртгүүлэх, худалдан авах норм дүрмийн процессын танилцуулгыг алхам алхамаар харуулах;
 - Авто замын норм нормативын сангийн функц
 - Төлөвлөгөө
 - Тайлан
 - Тушаал, дүрэм журам
 - Мэргэжлийн зөвлөл
 - Бусад нэмэлт хөгжүүлэлт хийх
6. Төслийн эцсийн үр дүн:
7. Төслийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, хэмжээ:
8. Гүйцэтгэх багт тавигдах шаардлага:
- Авто замын норм нормативын сангийн цахим системд нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалтыг хийж гүйцэтгэсэн байна.
 - Авто замын норм нормативын сан
 - 20.0 сая төгрөг
 - Программ хангамж хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллага,
 - Аж ахуй нэгж байгууллага нь үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх,
 - Программ хангамж хөгжүүлэгч (Full-stack, DevOps), UI/UX дизайнер, мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн

**9. Төслийн онцгой
нөхцөл:**

- Цахим системийн хөгжүүлэлт, боловсруулалтыг гүйцэтгэж үйлчилгээ эрхэлж байсан туршлагатай байх
- Авто замын тухай хууль болон бусад хууль дүрэм журам, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм журамд нийцүүлэн боловсруулалтыг гүйцэтгэх
- Системийн дата өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг дангаар хариуцах.
- Хуучин программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хариуцах.
- Шинэ хөгжүүлэлтийн нэвтрүүлэлт, аюулгүй ажиллагааг бүрэн хангах.
- Төслийн хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, программ хангамж, түүний эх код нь “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн 17.2 дах заалт, 8 дугаар зүйлийн дагуу Захиалагч “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын өмч болно.

ХЯНАСАН:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга

 Э.БАЛТ

БОЛОВСРУУЛСАН:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн ахлах мэргэжилтэн

 Т.БАТБОЛД

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн мэргэжилтэн

 О.ДОЛГИОН